



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 24/23

Улаанбаатар хот

Г Барилга акталж, нийслэлийн өмчийн Т  
бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 80 дугаар зүйлийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Баянхошуу дэд төвд хэрэгжүүлж, усан спорт цогцолборын барилгын ажил хийгдэж байгаатай холбогдуулан Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн баланст бүртгэлтэй нийт 7,205,923.00 (долоон сая хоёр зуун таван мянга есөн зуун хорин гурав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 7,205,923.00 (долоон сая хоёр зуун таван мянга есөн зуун хорин гурав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий гүний худгийн барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

111010157

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн  
 211/2025 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ГҮНИЙ ХУДГИЙН БАРИЛГА

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Гүний худаг	24	ш	1	7,205,923.00	7,205,923.00	7,205,923.00	-
Нийт дүн						<b>7,205,923.00</b>	<b>7,205,923.00</b>	